

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮНДЭСНИЙ ТОВЛОЛЫГ ШИНЭЧЛЭХ ТУХАЙ

Дархлаажуулалтын тухай хуулийн 10.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Дархлаажуулалтын үндэсний шинэ товллыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 2006 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайд Л.ГҮНДАЛАЙ

**МОНГОЛ УЛСАД МӨРДӨХ ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
ҮНДЭСНИЙ ТОВЛОЛ**

| № | Сэргийлэх тарилгын нэр | Эхлэл дархлаажуулалт | Дархлал сэргээх /давтан/ дархлаажуулалт |
|---|--|--|--|
| 1 | Сүрьеэгийн эсрэг сэргийлэх тарилга (БЦЖ) | Төрсний дараа 24 цагийн дотор | |
| 2 | Полиомиелитийн (Хүүхдийн тархи нугасны халдварт саа) эсрэг сэргийлэх тарилга | Нэг дэх тунг төрсний дараа 24 цагийн дотор | |
| | | Хоёр дахь тунг хоёр сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэг дэх тун, В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын хоёр дахь тунтай нэгэн зэрэг | |
| | | Гурав дахь тунг гурван сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын хоёр дахь тунтай нэгэн зэрэг | |
| | | Дөрөв дэх тунг дөрвөн сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын гурав дахь тунтай нэгэн зэрэг | |
| 3 | В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилга | Нэг дэх тунг төрсний дараа 24 цагийн дотор | |
| | | Хоёр дахь тунг хоёр сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл, дархлаажуулалтын хоёр дахь тун, сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэг дэх тунтай нэгэн зэрэг | |
| | | Гурав дахь тунг наймаас арван нэгэн сартайд улаанбурхны эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэг дэх тунтай нэгэн зэрэг | |
| 4 | Сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилга | Нэг дэх тунг хоёр сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилгын болон В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын хоёр дахь тунтай нэгэн зэрэг | Хоёр настайд нь дархлал сэргээх дархлаажуулалтын нэг тунг хийнэ. |
| | | Хоёр дахь тунг гурван сартайд нь | |

| | | | |
|---|---|---|--|
| | | полиомиелитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын гурав дахь тунтай нэгэн зэрэг | |
| | | Гурав дахь тунг дөрвөн сартайд нь полиомиелитын эсрэг сэргийлэх тарилгын дөрөв дэх тунтай нэгэн зэрэг | |
| 5 | Сахуу, татрангийн эсрэг сэргийлэх тарилга /Дархлал сэргээх тун/ | | Нэг дэх тунг 7 насанд. Хоёр дахь тунг 15 насанд хийнэ. |
| 6 | Улаанбурхны эсрэг сэргийлэх тарилга | Нэг дэх тунг наймаас арван нэгэн сартайд нь В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын гурав дахь тунтай нэгэн зэрэг | |
| | | Хоёр дахь тунг нэг насанд нь нэгдэх тунгаар дархлаажуулснаас хойш 6-10 сарын дараа хийнэ. | |

Тайлбар: Вакцины тунгийн хэмжээ, хэрэглэх аргыг тухайн вакцины шинж чанар, үйлдвэрлэгчийн зааврыг үндэслэн Эрүүл мэндийн яам тухай бүр тогтоож байна.